



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН ТӨА-2024/255/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пейж Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/80

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 256,838.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019020097



Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэг “Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98,2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,233,431.88</u>	<u>277,369,696.49</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,656,146.00	256,838,238.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	50,656,146.00	256,838,238.61
3121	Төгрөг	50,656,146.00	256,838,238.61
31211	Төрийн сангийн харилцах	50,656,146.00	256,838,238.61
35	БАРАА МАТЕРИАЛ	20,577,285.88	20,531,457.88
354	Хангамжийн материал	20,577,285.88	20,531,457.88
35420	Аж ахуйн материал	11,672,950.00	12,122,950.00
35430	Сэлбэг хэрэгсэл	91,500.00	91,500.00
35450	Барилгын засварын материал	240,000.00	240,000.00
35460	Хүнсний материал	5,583,133.88	508,649.88
35470	Бусад хангамжийн материал	2,989,702.00	7,568,358.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,257,438,157.28</u>	<u>1,597,457,929.79</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,257,438,157.28	1,597,457,929.79
392	Биет хөрөнгө	1,243,250,157.28	1,583,269,929.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,307,306,396.00	1,720,053,796.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-119,881,248.30	-206,228,529.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,989,334.00	48,493,127.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,671,584.01	-25,803,534.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,211,212.48	53,591,517.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,461,397.45	-26,355,558.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,154,100.00	32,231,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,209,655.44	-13,525,388.77
39217	Ном	813,000.00	813,000.00
393	Биет бус хөрөнгө	14,188,000.00	14,188,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,188,000.00	14,188,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,328,671,589.16</u>	<u>1,874,827,626.28</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,328,671,589.16</u>	<u>1,874,827,626.28</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,328,671,589.16	1,874,827,626.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	73,871,479.00	73,871,479.00
51101	Өмч: - төрийн	73,871,479.00	73,871,479.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,241,616,657.86	1,787,772,694.98
51210	Өмнөх үеийн үр дүн	1,241,616,657.86	1,241,616,657.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	546,156,037.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,183,452.30	13,183,452.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,328,671,589.16</u>	<u>1,874,827,626.28</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,913,866,907.89	1,234,465,227.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,789,208,007.89	409,648,727.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,340,243,807.89	409,648,727.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,340,243,807.89	409,648,727.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	448,964,200.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	448,964,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,658,900.00	824,816,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	95,988,400.00	740,351,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	95,988,400.00	740,351,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,670,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,670,500.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	84,465,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	84,465,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	583,895,458.73	685,302,868.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	583,895,458.73	685,302,868.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	550,829,275.73	680,789,933.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,039,856.00	387,698,567.33
210101	Үндсэн цалин	251,441,103.00	299,939,588.24
210102	Нэмэгдэл	51,459,675.00	80,373,103.09
210104	Урамшуулал	4,139,078.00	7,385,876.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,768,544.00	51,104,870.06
210201	Тэтгэврийн даатгал	28,332,825.42	35,449,096.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,274,499.64	4,148,802.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,461,679.61	3,125,511.97
210204	Ажилгүйдлийн даатгал	602,755.26	757,697.60
210205	Эрүүл мэндийн даатгал	6,096,784.07	7,623,761.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,206,791.00	83,164,265.43
210301	Гэрэл, цахилгаан	5,547,591.00	8,623,931.10
210302	Түлш, халаалт	61,259,200.00	68,440,334.33
210303	Цэвэр, бохир ус	4,400,000.00	6,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,298,042.56	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	2,194,542.56	00.00
2105	Нормативт зардал	52,720,040.12	67,606,884.00
210502	Хоол, хүнс	52,720,040.12	67,606,884.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	850,000.00	750,000.00
210604	Урсгал засвар	850,000.00	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,100,300.00	1,235,700.00



210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,300.00	1,235,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,845,702.05	89,229,647.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,133,910.00	13,996,070.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,528,475.00	3,707,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,183,317.05	71,526,477.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,066,183.00	4,512,934.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,567,000.00	3,962,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,660,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,906,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,962,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,499,183.00	550,934.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,499,183.00	550,934.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,329,971,449.16</u>	<u>549,162,358.52</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,799,415.00	3,006,321.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,799,415.00	3,006,321.40
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,799,415.00	-3,006,321.40
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,328,172,034.16</u>	<u>546,156,037.12</u>



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	573,623,100.00	824,816,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	448,964,200.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	448,964,200.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	448,964,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,658,900.00	824,816,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	95,988,400.00	740,351,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	95,988,400.00	740,351,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,670,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,670,500.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	84,465,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	84,465,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	522,809,954.00	609,151,907.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	522,809,954.00	609,151,907.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,743,771.00	604,638,972.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,039,856.00	387,698,567.33
210101	Үндсэн цалин	251,441,103.00	299,939,588.24
210102	Нэмэгдэл	51,459,675.00	80,373,103.09
210104	Урамшуулал	4,139,078.00	7,385,876.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,268,989.00	51,104,870.06
210201	Тэтгэврийн даатгал	27,833,270.42	35,449,096.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,274,499.64	4,148,802.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,461,679.61	3,125,511.97
210204	Ажилгүйдлийн даатгал	602,755.26	757,697.60
210205	Эрүүл мэндийн даатгал	6,096,784.07	7,623,761.85
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,206,791.00	83,164,265.43
210301	Гэрэл, цахилгаан	5,547,591.00	5,724,931.10
210302	Түлш, халаалт	61,259,200.00	68,440,334.33
210303	Цэвэр, бохир ус	4,400,000.00	8,999,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
2105	Нормативт зардал	53,511,950.00	62,532,400.00
210502	Хоол, хүнс	53,511,950.00	62,532,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	850,000.00	750,000.00
210604	Урсгал засвар	850,000.00	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,100,300.00	1,235,700.00



210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,300.00	1,235,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,662,385.00	18,153,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,133,910.00	14,446,070.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,528,475.00	3,707,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,066,183.00	4,512,934.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,567,000.00	3,962,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,660,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,906,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,962,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,499,183.00	550,934.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,499,183.00	550,934.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>50,813,146.00</u>	<u>215,664,592.61</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	157,000.00	9,482,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	157,000.00	9,482,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	157,000.00	9,482,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	157,000.00	9,482,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-157,000.00</u>	<u>-9,482,500.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	50,656,146.00	206,182,092.61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	50,656,146.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,656,146.00	256,838,238.61



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,871,479.00	14,898,857.49	-28,613,925.34	60,156,411.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,598,155.49	1,598,155.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,871,479.00	14,898,857.49	-27,015,769.85	61,754,566.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,300,949,048.79	1,300,949,048.79
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,871,479.00	13,183,452.30	1,241,616,657.86	1,328,671,589.16
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,871,479.00	13,183,452.30	1,241,616,657.86	1,328,671,589.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,871,479.00	13,183,452.30	1,241,616,657.86	1,328,671,589.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	546,156,037.12	546,156,037.12
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,871,479.00	13,183,452.30	1,787,772,694.98	1,874,827,626.28



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	794,007,500.00	533,259,657.39	260,747,842.61	67.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	794,007,500.00	533,259,657.39	260,747,842.61	67.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	789,991,500.00	529,297,657.39	260,693,842.61	67.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,361,700.00	387,698,567.33	201,663,132.67	65.78
210101	Үндсэн цалин	394,116,000.00	299,939,588.24	94,176,411.76	76.10
210102	Нэмэгдэл	185,161,100.00	80,373,103.09	104,787,996.91	43.41
210104	Урамшуулал	10,084,600.00	7,385,876.00	2,698,724.00	73.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,670,200.00	51,104,870.06	22,565,329.94	69.37
210201	Тэтгэврийн даатгал	50,095,600.00	35,449,096.26	14,646,503.74	70.76
210202	Тэтгэмжийн даатгал	5,893,800.00	4,148,802.38	1,744,997.62	70.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,714,800.00	3,125,511.97	1,589,288.03	66.29
210204	Ажилгүйдлийн даатгал	1,178,800.00	757,697.60	421,102.40	64.28
210205	Эрүүл мэндийн даатгал	11,787,200.00	7,623,761.85	4,163,438.15	64.68
2105	Нормативт зардал	97,550,500.00	62,532,400.00	35,018,100.00	64.10
210502	Хоол, хүнс	97,550,500.00	62,532,400.00	35,018,100.00	64.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,235,700.00	1,235,700.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,235,700.00	1,235,700.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,173,400.00	26,726,120.00	1,447,280.00	94.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,466,300.00	23,019,020.00	1,447,280.00	94.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,707,100.00	3,707,100.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,016,000.00	3,962,000.00	54,000.00	98.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,016,000.00	3,962,000.00	54,000.00	98.66
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,016,000.00	3,962,000.00	54,000.00	98.66
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	794,007,500.00	740,351,300.00	53,656,200.00	93.24
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	794,007,500.00	740,351,300.00	53,656,200.00	93.24
131001	Улсын төсвөөс санхүүжих	794,007,500.00	740,351,300.00	53,656,200.00	93.24
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	50,656,146.00	-50,656,146.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	256,838,238.61	-256,838,238.61	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10	10	0.00	100.00



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ, арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, цахим шилжилт, сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багш, удирдах ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, үр ашигтай байдлаар үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх бөгөөд бодлого, үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан байх;
- Тогтвортой, уялдаатай, уян хатан байх;
- Тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх;
- Төр, олон нийтийн оролцоог хангасан, хамтын хариуцлагатай байх;
- Насан туршийн суралцахуйг дэмжсэн байх;
- Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн байх, улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх.

Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтална.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Цэцэрлэг нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Хөрөнгийн үнэлгээний тухай хууль



- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 237,086.8 мянган төгрөгөөр буюу 11,04 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	50,656.15	256,838.24	206,182.09
Авлага			-
Бараа материал	20,577.29	20,531.46	(45.83)
Үндсэн хөрөнгө	1,257,438.16	1,597,457.93	340,019.77
Нийт хөрөнгө	1,328,671.59	1,874,827.63	546,156.04
Өр төлбөр			-
Хуримтлагдсан үр дүн	1,241,616.66	1,787,772.69	546,156.04
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,183.45	13,183.45	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	73,871.48	73,871.48	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,328,671.59	1,874,827.63	546,156.04



Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө өөрчлөлттэй байна. Үүнд:

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 256,838.24 мянган төгрөгөөр харагдаж байгаа нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Бараа материал буурсан нь хоол хүнсний материалаар буурсан.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 340,019.7 мянган төгрөгөөр өссөн “Номин” хувийн цэцэрлэгээс шилжиж ирсэн хичээлийн хэрэглэгдэхүүн хандиваар авсан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 895,500.5 мянган төгрөг, нийт зарлагыг 895,500.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2023 оны зардлыг 101.4 мянган төгрөгөөр бууруулж, 794,007.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2023 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл төсвийн хэмнэлтийн хуулиас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 794,007.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 84,465.2 мянган төгрөгийг орон нутгийн сангаас бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 794,007.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 533,259.6 мянган төгрөг буюу 80 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 260,747.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийг дэмжих	18,536.00	18,536.00	-	100,0
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	830,467.00	510,286.00	320,181.00	61,4
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	51,542.00	51,542.00	-	100,0
4	Багш ажилчдын сургалт	18,536.00	13,160.00	5,376.00	71,0
5	Нүүдлийн бүлэг хамруулах	369,017.00	351,109.00	17,908.00	95,1
6	Боловсролын стандарт	5,340,630.00	3,342,735.00	1,997,895.00	62,5
7	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	1,281,347.00	1,054,323.00	227,024.00	82,2



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Ц.Цацрал, Х.Ариунжаргал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, үе шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 11/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,913,866.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 28,708.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21,531.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, албан томилолтоор ажилласан зардал хэмнэж ажилласан хэдий ч байгалийн гамшиг, цас, зудын нөхцөл байдалтай уялдуулан онцгой дэглэмээр ажиллаж байгаа шалтгаан нөхцөлийн улмаас зардлын хэмнэлтийг хийх боломжгүй нөхцөл байгааг анхаарч үзсэн болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 1 мэдээлэл, мэдээлээгүй 5 мэдээлэл байршуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.
2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Хит повер ресурс ХХК-ийн 34,210.9 мянган төгрөгийн зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд дээр хөрөнгийн хэмжээ 36,871.0 мянган төгрөг, санхүү байдлын тайланд төрийн өмч 73,871.5 мянган төгрөг, Засгийн газрын оролцоо 36,871.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-д үнэн зөв байх; гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцооллын алдаагүй үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.



Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, баримтжуулалтын талаар, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэлтэй холбоотой нийт 7 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 333.1 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс 333.1 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	333.1	1	333.1	100.0
Нийт дүн	1	333.1	1	333.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд нийт хувьсах зардлын 2 хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна гэснийг үзэх,
2. Боловсролын шинэчлэлтийн хуулиар олгогдсон бусад эрх хэмжээний асуудлыг үзэх

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,272.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 435.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 13,979.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Татварын цахим тайлангийн системээр газрын төлбөр, малын тоо толгойн албан татвар 293.3 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй”; гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



2. Бараа материал худалдан авалт хийх, бэлтгэхдээ үнийн харьцуулалт хийгээгүй, хэдэн төгрөгөөр ямар төрлийн бараа үйлчилгээ авах нь тодорхойгүй, гэрээ байгуулан гэрээний үүргийн хяналтыг хэрэгжүүлээгүй, сумын Засаг даргын Тамгын газраас худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг гэсэн хэдий ч хүчин төгөлдөр баримтаар нотлогдохгүй, ил тод байх, мэдээлэл авах эрхийг ханган ажиллаагүй, албан тушаалын давуу байдал бий болсон, шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 50 дугаар зүйлийн 50.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараах үүрэг хүлээнэ", 50.1.1-д "шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх", 50.1.2-т "төрийн ашиг сонирхлыг дээдлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэсэнтэй нийцээгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, тайлангийн эрх ба үүрэг, толилуулга, иж бүрэн зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 1,414.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн ханган ажиллах.



2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын 2 нэр төрлийн үндсэн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн. Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн жагсаалт, мэдээллийг тодруулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь СТОУС-13 стандартын 6.12-д “Бодит үнэ цэнэ гэж зах зээлд оролцогчдын хоорондох цэгцтэй ажил гүйлгээгээр хэмжилтийн өдөр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх үнийн дүн юм”, 6.13-д “Бодит үнэ цэнд зах зээлд оролцогчид буюу тухайн аж ахуйн нэгж нэвтрэх боломжтой зах зээлд оролцогчдын хэтийн төлөв тусгагддаг. Эдийн засгийн ашиг тусын төлөө хамгийн сайн үйл ажиллагаа эрхэлдэг бол хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо тэдний ашиглаж болох ижил төстэй таамаглалыг ашиглан, тэдгээр хөрөнгө өр төлбөрийг хэмждэг” гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж, тайлагнадаг байх зөвлөмж хүргүүлэв.

3. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 12,305.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн, баримтжуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын төлбөр, Малын тоо толгойн албан татвар 293.3 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй	1	293.3			1	293.3						
Бараа материал худалдан авалт хийх, бэлтгэхдээ үнийн харьцуулалт хийгээгүй	1				1							
Анхан шатны цахим баримт 1,414.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн	1	1,414.5					1	1,414.5				
Үндсэн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн	1	260.0					1	260.0				
Цахим баримт 12,305.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	1	12,305.0					1	12,305.0				
Дүн	4	14,272.8			2	293.3	3	13,979.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 1 мэдээлэл, мэдээлээгүй 5 мэдээлэл байршуулсан байна.	1				1			
Хит повер ресурс ХХК-ийн 34,210.9 мянган төгрөгийн зарлагыг өссөн дүнгээр дутуу оруулсан байна.	1	34,210.9			1	34,210.9		
Дүн	2	34,210.9			2	34,210.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн газрын оролцоо 36,871.0 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	36,871.0					1	36,871.0
Дүн	1	36,871.0					1	36,871.0
Нийт дүн	3	71,081.9			2	34,210.9	1	36,871.0